


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

05.11 - 05.15



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд эдийн засгийн үзүүлэлтүүд муу байсантай холбоотой уналттай хаагдлаа. Зах зээлийн үнэлгээ багатай компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол эрүүл мэндийн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний болон тансаг бараа бүтээгдэхүүний салбарын компаниудын хувьцаа харьцангуй тогтмол байлаа. АНУ-д газрын тосны үнэ эргэн сэргэсэн ч эрчим хүчний салбар уналттай байлаа. Мөн жижиглэнгийн худалдаачид болон бусад бизнес эрхлэгчид түрээсээ төлөх чадваргүй болж байгаагаар холбоотой үл хөдлөх хөрөнгийн салбар мөн уналттай байлаа.

Лхагва гарагт S&P500 индекс 3 долоо хоногийн хамгийн доод цэгтээ хүрснээр арилжааны хувьд тус долоо хоногийн хамгийн муу өдөр тохиолдсон байна. Холбооны Нөөцийн Дарга Жером Пауэлл ярилцлагадаа, ирэх саруудад “маш том уналтын эрсдэл” хүлээж байгаа талаар мөн “эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадал хэсэгтээ сэргэх боломжгүйгээр гэмтэнэ” хэмээн анхааруулсан нь хөрөнгө зах зээлийн индексүүд сулрахад нөлөөлжээ. Хэдийгээр Жером Пауэлл эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн талаар мөн дурдсан боловч Холбооны Нөөцийн Сангаас бодлогын хүүний төвшинг 0%-аас бууруулах буюу сөрөг болгохыг зорихгүй байгаа гэж мэдэгдсэн нь зарим хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулсан байна.

**Европ:** Европт коронавирусын цар тахлын хоёр дахь давлагаа гарах магадлалтай байгаа нь эдийн засгийн уналтыг хүндрүүлэх эрсдэл үүсгэж байгаатай холбоотой энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индекс уналттай байлаа. STOXX Europe 600 индекс 3.44%, DAX индекс 3.84%, CAC 40 индекс 5.248%, FTSE MIB индекс 2.84% тус тус буурсан бол FTSE 100 индекс 2.29%-аар буурсан байна.

Eurostat-ийн үзэж байгаагаар 2020 оны эхний улиралд Евро бүсийн эдийн засаг түүхэн дэх хамгийн их буюу 3.8%-аар агшсан байна. Франц улсын эдийн засаг 5.8% буюу хамгийн их бууралттай байсан бол Словак улс 5.4%, Испани 5.2%, Итали 4.7% тус тус бууралттай байна. Харин Европын хамгийн том эдийн засагтай улс болох ХБНГУ-ын эдийн засаг 2.2%-аар буурсан үзүүлэлттэй байна.

**Япон:** Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Nikkei 225 Stock Average индекс 142 пункт буюу 0.7% буурч 20,037.47 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 15.3% бага байгаа юм. TOPIX индексүүдийн хувьд зах зээлд томоохон байр суурч эзлэгч компаниудын хувьцааны индекс буурч, харин жижиг компаниудын хувьцааны индекс өссөн байна. Тус 2 индекс нь өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад аль аль нь 15 орчим хувиар бага үнэлгээтэй байна. Харин иений ханшийн хувьд, Баасан гарагт 1 ам.доллар 107 иентэй тэнцэж байв.

**БНХАУ:** Долоо хоногийн дунд үе хүртэл БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй тогтвортой байсан ч АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп БНХАУ-ын эсрэг дахин “заналхийлэл” илэрхийлснээс болж хөрөнгийн зах зээлийн индексүүд унаж эхэлсэн байна. CSI 300 large-cap индекс 1.3%-аар, Shanghai composite индекс 0.9%-аар тус тус буурчээ. 4-р сарын зээлжилтийн болон эдийн засгийн голлох үзүүлэлтүүд таамаглалаас сайн гарсан байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,236.05	-1.83% ▼
Dow Jones	АНУ	23,685.42	-2.65% ▼
S&P 500	АНУ	2,863.70	-2.26% ▼
Nasdaq	АНУ	9,014.56	-1.17% ▼
S&P/TSX	Канад	14,638.90	-2.19% ▼
FTSE 100	Их Британи	5,799.77	-2.29% ▼
S&P/ASX 200	Австрали	5,404.80	0.25% ▲
Nikkei 225	Япон	20,037.47	-0.70% ▼
Hang Seng	Хонг Конг	23,797.47	-1.79% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	96.00
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	89.29
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	89.68
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	98.87
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.46
DBM' 2023	USD	7.250%	87.38
TDBM' 2020	USD	9.375%	99.77
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	76.12

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.172	-0.03 ▼
Libor 3M	0.381	-0.05 ▼
Libor 6M	0.659	-0.03 ▼
Libor 1YR	0.755	-0.03 ▼
US 2YR Bond	0.141	-0.02 ▼
US 3YR Bond	0.183	-0.03 ▼
US 5YR Bond	0.307	-0.03 ▼
US 10YR Bond	0.643	-0.05 ▼

Валютын ханш	2020.05.15	Өөрчлөлт
USD	2,796.80	0.19% ▲
CNY	394.00	-0.12% ▼
EUR	3,025.02	-0.04% ▼
RUB	38.27	1.24% ▲
KRW	2.27	-0.87% ▼
JPY	26.12	-0.46% ▼
CAD	1,995.15	-0.32% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,743.67	2.41% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	16.61	7.30% ▲
Зэс	USD/lb.	233.05	-3.14% ▼
Нүүрс	USD/MT	54.57	0.63% ▲
WTI газрын тос	USD/bbl.	29.43	18.96% ▲
Brent газрын тос	USD/bbl.	32.50	4.94% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. III	6.4%
Бодлогын хүү	2020. III	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. III	10.18%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. III	11.41%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. III	4.67%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. III	17.07%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. III	10.34%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 32 компанийн 536.7 сая төгрөгийн 11,819,388 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Э-транс ложистикс” /ETR/ компанийн хувьцаа 13.67%-аар буюу хамгийн ихээр өсөж 158.00 төгрөг хүрч хаагдсан бол “Стандарт агрикалчер групп” /SON/ компанийн хувьцаа 18.31%-аар буурч 34.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


05-р сарын 15-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,432.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,236.05 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.83%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	536.7	
Зах зээлийн үнэлгээ	2,432,605.4	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,236.05	-1.83% ▼
MSE I индекс	7,760.09	-1.37% ▼
MSE II индекс	7,391.25	-0.61% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Стандарт агрикалчер групп	11,088,008	395,493,272
Силк нет	100,285	72,205,200
АПУ	27,597	14,892,784
Лэндмн ББСБ	340,898	11,270,971
Таван толгой	1,703	9,411,760

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Э-транс ложистикс	158.00	13.67% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	509.50	8.40% ▲
Ремикон	27.00	8.00% ▲
Монгол базальт	215.00	3.17% ▲
Материалимпекс	8,105.00	0.68% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Стандарт агрикалчер групп	34.00	-18.31% ▼
Сор	725.00	-9.38% ▼
Авто зам	3,000.00	-6.25% ▼
Говь	191.74	-6.24% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,330.00	-4.39% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Стандарт Инвестмент	811,204,732
Евразиа Капитал Монголиа	144,607,400
Би Ди Сек	23,212,543
Гаули	15,371,373
Ти Ди Би Капитал	13,462,569

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	539.00	573,594
Таван толгой	5,495.00	289,395
МИК Холдинг	11,000.00	227,803
Инвескор ББСБ	2,524.00	181,041
Говь	191.74	149,579

### Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-аас Монгол Улсад суугаа суурин төлөөлөгч Руфат Алимарданов нар Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр үзэглэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

## ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

### Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулагдана

2020 оны 05-р сарын 15-н ы байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа зохион байгуулахаар болсон байна. Үүнд:

1. “Монгол Шилтгээн” ХК 2020 оны 05-р сарын 25-ний өдрийн 13:00 цагт (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Самбуугийн гудамж, “Орон зай” төв 7 давхарт 704 тоот).
2. “Ингэттолгой” ХК 2020 оны 06-р сарын 20-ны өдрийн 10:00 цагт (Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ бүрэн баг, 3-р тасаг, Ингэттолгой ХК-ийн байр).
3. “Номин Хишиг” ХК 2020 оны 06-р сарын 21-ний өдрийн 10:00 цагт (Баянхонгор аймаг, Баянхонгор сум 1-р баг, “Номин хишиг” ХК-ийн байр).

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### “Баянгол зочид буудал” /MSE: BNG/ ХК-ийн 5.9%-тай тэнцэх хувьцааг худалдан авна

“Баянгол зочид буудал” /MSE: BNG/ ХК нэр бүхий хөрөнгө оруулагчдаас компанийнхаа нийт хувьцааны 5.9%-тай тэнцэх 25,000 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авахаар болсон байна.

Одоогоор хэлцэлийн дүн тодорхойгүй байгаа бөгөөд зах зээлийн ханшаар нь тооцвол 821.5 сая төгрөгийн үнэлгээтэй хувьцаа гэсэн үг.

Хувьцаагаа авах асуудлыг өнгөрсөн сард болсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, Төлөөлөн Удирдах Зөвлөлд эрхийг нь олгожээ. Хувьцаа худалдах саналыг “Би Ди Сек” /MSE: BDS/ ХК-аас ирүүлсэн аж.

Эх сурвалж: MarketInfo.mn

### “Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК хөрөнгийн үнэлгээ хийлгэхээс татгалзав

“Улсын их дэлгүүр” /MSE: UID/ компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04-р сарын 30-ны өдөр болж хэд хэдэн асуудлыг хэлэлцсэн аж.

Үүнд компанийн эд хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх асуудал багтсан бөгөөд уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн олонхи нь зөвшөөрөөгүй тул хурлаас татгалзах шийдвэр гаргасан байна.

“Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК-ийн хувьд 2019 оны тайлангийн үзүүлэлтээр 8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгаа ба Санхүүгийн Зохицуулах Хорооноос хувьцаат компаниудыг 2 жил тутам хөрөнгийн үнэлгээг хийлгэж байх шаардлага тавьдаг билээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

### “Стандарт агрикалчер групп” ХК-ийн нийт хувьцааны 42.2% нь дахин арилжигдав

2020 оны 05-р сарын 12-ны Мягмар гарагт “Стандарт агрикалчер групп” /MSE:SOH/ ХК-ийн хувьцааны 38.5% нь арилжигдсан ба 05-р сарын 14-ны арилжаагаар мөн тус компанийн 42.2% буюу 5,802,008 ширхэг хувьцаа 197.3 сая төгрөгөөр дахин арилжигдлаа.

Хэлцэл 9.33%-ийн ханшийн бууралттай үнээр буюу нэгж хувьцааны 34 төгрөгөөр хийгдсэн бөгөөд хувьцааны нийлүүлэлтийг, тус компанийн 98.94%-ийг дангаар эзэмшдэг “Стандарт капитал” ХХК-аас хийв.

Ийнхүү ойрхон 2 дараалсан хэлцэл явсан нь компани шинэ хөрөнгө оруулагчтай болж байгааг илэрхийлэх ба тус компани сүүлийн үед компаниуд ихээр хэрэгжүүлэх болсон өөр ХХК-ийг нэгтгэх үйл ажиллагаа явуулах магадлалтай юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

“COVID-19” цар тахлын хүн амын эрүүл мэнд, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэл болон Монгол Улсын эрчим хүчний системд анхны том хэмжээний хуримтлуурыг төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд барих зорилгоор зээлийн гурван хэлэлцээр, буцалтгүй тусламжийн нэг гэрээнд Азийн хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газар хооронд гарын үсэг зурлаа.

Эдгээр хэлэлцээрүүдэд цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах хөтөлбөрийн 100 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, цар тахлын эсрэг бэлэн байдал болон хариу арга хэмжээг дэмжих зорилгоор “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр” төслийн 30 сая ам.долларын нэмэлт санхүүжилт багтжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн II улирлын ээлжит хуралдаан 2020 оны 05-р сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Макро эдийн засгийн төлөв байдлын тухай
- Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор банк, санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

СТБЗ-ийн ээлжит хуралдааныг Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Х.Бум-Эрдэнэ даргалж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Эх сурвалж: BloombergTV.mn

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Улсын онцгой комиссоос гаргасан төмрийн хүдрийн экспортыг эхлүүлэх шийдвэрийн дагуу Засгийн газрын 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, Бургастай-Лаоемя боомтыг нээсэн талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Говь-Алтай аймгийн Цээл сумын нутаг дахь тус боомтоор “Алтайн хүдэр” ХХК жилд дунджаар 1-1.16 сая тонн төмрийн хүдэр экспортолж, улсын төсөвт 15.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт нэг тэрбум төгрөг төвлөрүүлсэн талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамны мэдээлэлд дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.